



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 7/161

Сүхбаатар сум

Төвийн бүсийн аймгуудын шилдэг сумаар шалгарсан Сайхан сумыг шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.17, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1, Төвийн бүсийн зөвлөлийн 2020 оны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, аймгаас баримтлан ажиллаж буй бодлого, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж, иргэдийнхээ ахуй амьдрал, орон нутгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтээрээ "Улсын тэргүүний сум шалгаруулах болзол"-ыг хангаж Төвийн бүсийн шилдэг сумаар шалгарсан Сайхан сумын төр, төсвийн байгууллагын хамт олон, аж ахуйн нэгж, иргэдэд талархал илэрхийлж, 16000 /Арван зургаан мянга/ төгрөгийн батламж, 10000000 /Арван сая/ төгрөгөөр урамшуулсугай.

2. Зардалд шаардагдах нийт 10016000 /Арван сая, арван зургаан мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.


3. Зардлын тайланг 2020 оны 07 дугаар сарын 20-ны дотор гаргаж тайлагнахыг Сайхан сумын Засаг дарга /О.Буяназ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020
оны 06 дугаар сарын 04 -ны өдрийн
А/161 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Гаргах зардлын нэр	Зардлын төрөл	Нийт
1	Аймгийн Засаг даргын нөөц	Талархал	16.000
2	хөрөнгө	Шагнал	10.000.000
Дүн			10.016.000

Төсөв гаргасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн

/Д.Хишигбат/

Төсөв хянасан:

Тооцооны нягтлан бодогч

/Ц.Уранцэцэг/